

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



*Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын
2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу хийсэн
аудитын тайлан*

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИТ, ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР АШИГ

*Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйгээс
засаглалыг хөгжүүлэх бодлого, шийдвэрийн хэрэгжилт хангалтгүй байна.*

АГУУЛГА

Аудитын тайлан баталгаажуулсан тушаал.....	2
Товчилсон үгийн тайлбар	3
Хүснэгтийн товъёг	4
Дүрслэлийн товъёг	4
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх.....	5
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5
БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГО, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА	8
1.1. Орон нутгийн өмчит компанийн засаглалыг хөгжүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна..	8
1.1.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль нь орон нутгийн өмчит компанийн засаглалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна	8
1.1.2 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн компанийн засаглалыг үнэлэх тусгайлсан зарчим, аргачлал батлаагүй байна.....	9
1.1.3 Орон нутгийн эрх бүхий байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөрт компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилт, үндсэн чиглэлийг тусгаагүй байна	9
1.2 Орон нутгийн өмчит компанийн бодлого шийдвэр хуульд нийцээгүйгээс засаглалыг хөгжүүлэх зорилт хэрэгжихгүй байна.....	11
1.2.1 Орон нутгийн эрх бүхий байгууллагаас компанийн засаглалыг хөгжүүлэх бодлого шийдвэр гаргаагүй байна ..	11
1.2.2 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуульд заасан эрхээ хэрэгжүүлээгүйгээс ТУЗ-ийн тогтоол шийдвэр хуульд нийцэхгүй байна	11
БҮЛЭГ 2. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД ЗАРЦУУЛСАН ХАНДИВ ТУСЛАМЖ АЛДАГДЛЫГ НЭМЭГДҮҮЛСЭН БАЙНА.....	13
2.1. Эдийн засгийн зорилтот түвшнийг үндэслэлгүй төлөвлөсөн байна.....	13
2.1.1 Компанийн зорилтот түвшний тодотголыг хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэлгүй байна	13
2.1.2 Орон нутгийн өмчит компанийн эдийн засгийн зорилтот түвшнийг ТУЗ-өөс өөр эрх бүхий байгууллага хянаж баталдаггүй байна	14
2.1.3 Тус компанийн эдийн засгийн зорилтот түвшнийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн баталж байна	14
2.2. Төлөвлөсөн орлогоо сүүлийн 3 жил давуулан биелүүлжээ.....	14
2.2.1. Борлуулалтын орлогыг бүрэн төвлөрүүлж чадаагүй байна	14
2.2.2. Татвар, төлбөр хураамжийн өр өмнөх оноос буурсан байна	15
2.3. Усны борлуулалтын үнэ бүтээгдэхүүний өртөөс бага байна	16
2.3.1. Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн үр ашгийн тооцоо, шинжилгээ бодитой байна.....	16
2.3.2. Санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийн тооцоо шинжилгээ хийсэн боловч дүгнээгүй байна	17
2.3.3. Шинээр байгуулах хорооллын дэд бүтцийн ажлыг гэрээний хугацаанд гүйцэтгэжээ.....	18
2.4. Хандив тусламжийн зардал алдагдлыг нэмэгдүүлсэн байна	18
2.4.1. Батлагдсан төсвийн зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна.....	18
2.4.2. Нийгмийн хариуцлагын хүрээний зардлыг 82.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна	19
2.4.3. Төлөвлөгөөнд тусгаадаагүй худалдан авалт хийсэн байна	20
БҮЛЭГ 3. ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙГАА БОЛОВЧ ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА.....	22
3.1. Хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй байна	22
3.1.1 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тавих төрийн байгууллагуудын хяналт үр нөлөөтэй байна.....	22
3.1.2 Төрийн байгууллагуудаас санхүүгийн үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн хяналт үр нөлөөтэй байна	22
3.2. Санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна	23
3.2.1 Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа хангалтгүй байна.....	23
3.2.2 Компанийн дотоод хяналт нь санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хийгээгүй байна	23
3.3. Компанийн мэдээллийн ил тод байдал хангалтгүй байна	24
3.3.1 Дээд шатны байгууллагуудаас гаргасан өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэрүүдийг хэрэгжүүлж ажиллажээ.....	24
3.3.2 Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг олон нийтэд мэдээлээгүй байна	24
Холбогдох байгууллагаас ирсэн санал:.....	25
ДҮГНЭЛТ:.....	29
ЗӨВЛӨМЖ:.....	30

Аудитын тайлан баталгаажуулсан тушаал



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒᠒ оны ᠐7 сарын ᠐1 өдөр

Дугаар А/15

Дархан сум

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үндэсний аудитын газрын нэгдсэн төлөвлөгөө, Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу "Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг" гүйцэтгэлийн аудитын хүрээнд "Дархан-Ус суваг" ХК-ийн үйл ажиллагааны үр ашиг"-т хийсэн тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар тогтоосон 03/78-A0970287-ДАА-2022/22-7-ШТА-ГА тоот төлбөрийн актыг баталсугай.

3. Аудитын тайланг Дархан-Уул аймгийн ИТХ, аймгийн Засаг дарга, "Дархан-Ус суваг" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл, "Дархан-Ус суваг" ХК-д тус тус хүргүүлсүгэй.

4. Аудитаар тогтоосон төлбөрийн акт, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Дархан-Уул аймгийн ИТХ-ын дарга (С.Насанбат), аймгийн Засаг дарга (Б.Азжаргал), "Дархан-Ус суваг" ХК-ийн ТУЗ-ийн дарга (Г.Эрдэнэсүх), "Дархан-Ус суваг" ХК-ийн гүйцэтгэх захирал (Г.Эрдэнэбат) нарт зөвлөсүгэй.

5. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын архивд хүлээлгэн өгч, төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын баг (аудитор Ч.Гантулга, Н.Отгонцэцэг) нарт үүрэг болгосугай.

6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (У.Батсүрэн)-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ш.МӨНХБАЯР

009010040

E:\Бичиг хэрэг\Тушаал.docx

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗУХХ	Захиргаа удирдлагын хуулийн хэлтэс
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НАМЭХ	Нийгмийн ардчилал, Монголын эмэгтэйчүүдийн холбоо
НҮТББ	Нэгдсэн Үндэстний төрийн бус байгууллага
ОХУ	Оросын холбооны улс
УИХ	Улсын Их Хурал
ТББ	Төрийн бус байгууллага
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ХСУХАТАҮЗЗ	Хот, суурины ус хангамж, ариутгах татварын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл
ХК	Хувьцаат компани
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани



Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт №1	Татварын өрийн судалгаа	14
Хүснэгт №2	Батлагдсан орлого, зардлын төлөвлөгөө, тодотгол	16
Хүснэгт №3	Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний орлого, зардлын тооцоо	17
Хүснэгт №4	Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	17
Хүснэгт №5	Цалингийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	18
Хүснэгт №6	Нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулах зардлын төсөв, гүйцэтгэл	18

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл №1	Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл	12
Дүрслэл №2	Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл	12
Дүрслэл №3	Борлуулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл	13

Хавсралтын товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хавсралт №1	"Дархан-Ус суваг" ХК-ийн эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл	31
Хавсралт №2	"Дархан-Ус суваг" ХК-ийн 2021 оны төлөвлөгөө, тодотгол	32

**Аудит хийх
үндэслэл, бүрэн эрх**

**Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн
талаарх мэдэгдэл**

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой зарим хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтын үр нөлөөг үнэлж дүгнэн, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Компанийн засаглалыг хөгжүүлэх төрийн бодлого үр дүнтэй эсэх;
- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагаа үр ашигтай эсэх;
- Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн хяналт үр нөлөөтэй эсэх;

**Аудитын хамарсан
хүрээ**

Аудитыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Компанийн тухай хууль, УИХ, Засгийн газраас гаргасан тогтоол, тухайн хуулийн этгээдийн ТУЗ-өөс гаргасан шийдвэр, бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хэрэгжилтийн хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн компанийн засаглал, үйл ажиллагааны үр ашиг, хяналтыг хэрэгжүүлэхэд оролцогч хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх удирдлага, холбогдох төрийн захиргааны болон мэргэжлийн байгууллага, тэдгээрийн ажлын албадын 2019-2021 оны үйл ажиллагааг хамруулан, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан гүйцэтгэв.

**Аудитын
хязгаарлалт**

**Аудитын арга зүй,
шалгуур үзүүлэлт**

Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС-100, 300, 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж УДИР 3910, УДИР 3920, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, МҮЕА-ын баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг баримтлан аудитын зорилт, асуудлын шинжилгээний асуултад хариулт өгөхөд шаардагдах шалгагдагч байгууллагаас авсан бүх төрлийн нотлох зүйлсийг нягтлан

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

шалгаж, нөхцөл байдлын шинжилгээ хийж, аудитын дүнд суурилан дүгнэлт өгч, зөвлөмж боловсрууллаа.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер У.Батсүрэн хэрэгжүүлж, аудитор Ч.Гантулга, Н.Отгонцэцэг нар төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хугацаанд нь хийж гүйцэтгэв.

Хүндрэл бэрхшээл

.....



Ерөнхий мэдээлэл

“Дархан-Ус суваг” ХК нь анх БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1965 оны 3 дугаар сарын 17-ны өдрийн 68 дугаар тогтоолоор Дархан хотод “Ус сувгийн товчоо” нэртэйгээр цэвэр усны анги, сувагжуулах анги, засвар цех, автограш, цахилгаан диспетчер зэрэг анги салбаруудтай 34 ажлын байртай байгуулагдан улмаар аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2003 оны 09 дүгээр тогтоолоор “Дархан-Ус суваг” ХК болж орон нутгийн өмчит компани болжээ.

Компанийн 60 хувийг аймгийн ИТХ, 40 хувийг аймгийн Засаг даргын Тамгын газар эзэмшдэг бөгөөд 8 хэлтэс, алба нэгжид хөдөлмөрийн гэрээгээр 206 үндсэн ажилтан, түрээсийн гэрээгээр 19 хүн, хамгаалах салаанд 20 хүн, нийт 245 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус байгууллага нь Дархан хотын хүн амын хүнсний аюулгүй байдал, стратегийн чухал ач холбогдолтой гүний цэнгэг, стандартын шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн болох цэвэр ус олборлох, хангах, түгээх, бохир усыг татан зайлуулах, засвар үйлчилгээ бүхий цогц үйл ажиллагааг хэрэгжүүлэгч, Дархан-Уул аймгийн эрчим хүчний 1-р зэргийн хэрэглэгч хувьцаат компани юм.

Дархан хотын 1,500 гаруй үйлдвэр аж ахуйн нэгж, 14,000 гаруй айл өрхтэй цэвэр усаар ханган, бохир усыг татан зайлуулах гэрээ байгуулан, гэр хорооллын 28 мянга гаруй хүн амд зөөврөөр 19, төвлөрсөн сүлжээгээр 26 цэг, машинд ус ачих 2 цэг нийт 45 ус түгээх цэгүүдээр дамжуулан үйлчилж байна.

Компанийн бизнес төлөвлөгөөний орлого, зарлагыг ТУЗ-ийн тогтоолоор анх баталсан төсвийг 2019 онд 4 удаа тодотгон нийт зардлыг 3,029.6 сая, 2020 онд 1 удаа тодотгон нийт зардлыг 147.3 сая, 2021 онд 2 удаа тодотгон нийт зардлыг 123.3 сая төгрөгөөр тус тус нэмж баталжээ. Гүйцэтгэлээр 2021 онд орлого 113.5 хувь, зардал 100.7 хувьтай гарч 2,258.5 сая төгрөгийн алдагдалтай ажилласан нь өнгөрсөн оноос 14 хувиар буурсан байна.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ӨМЧИТ КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТӨРИЙН БОДЛОГО, ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

1.1. Орон нутгийн өмчит компанийн засаглалыг хөгжүүлэх хууль эрх зүйн орчныг сайжруулах шаардлагатай байна

1.1.1 Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Компанийн тухай хууль нь орон нутгийн өмчит компанийн засаглалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, эзэмших, ашиглах, захиран зарцуулах, хувьчлах зэрэг зөвхөн эд хөрөнгийн эрхийн тухай заасан нь орон нутгийн өмчит компанийн засаглалыг хөгжүүлэх хэрэгцээ шаардлагыг бүрэн хангахгүй байна.

Харин Компанийн тухай хуулиар хувьцаа эзэмшигчдийн эрх үүрэг, ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх хороо, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх удирдлагыг сонгох, томилох, тэдгээрийн үйл ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулахаар заажээ.

Компанийн тухай хуулийн 2011 оны шинэчилсэн найруулгаар 79 дүгээр зүйлд “ТУЗ-ийн хараат бус гишүүн”, 81 дүгээр зүйлд “ТУЗ-ийн дэргэдэх хороо”, 82 дугаар зүйлд “ТУЗ-ийн нарийн бичгийн дарга” зэргийг нэмж баталснаар компанийн засаглалын тогтолцооны бүрэлдэхүүнд багтах ТУЗ-ийн эрх үүрэг, оролцоог бүрэн тодорхойлжээ. Тухайлбал:

- Хуулийн 75 дугаар зүйлд хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн ТУЗ-ийн гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байх, мөн бүх гишүүд болон ТУЗ-ийн нарийн бичгийн дарга компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авахыг,
- Хуулийн 76 дугаар зүйлд ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг ТУЗ-өөс батлахыг,
- Хуулийн 79 дүгээр зүйлд ТУЗ-ийн хараат бус гишүүдэд тавих шалгуур, сонгон шалгаруулалт, тэдний нэмэлт эрх үүргийг,
- Хуулийн 80 дугаар зүйлд ТУЗ-ийн хурлын тэмдэглэлд хуралд оролцсон ТУЗ-ийн гишүүд гарын үсэг зурах, хэрэв аль нэг гишүүн хурлын тэмдэглэлд гарын үсэг зурахаас татгалзсан бол энэ тухай бичгээр тайлбар гаргахыг,
- Хуулийн 81 дүгээр зүйлд хувьцаат компанийн ТУЗ нь гуравны хоёроос доошгүй хараат бус гишүүдээс бүрдсэн аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодыг байгуулах, ТУЗ-ийн хороодын бүрэн эрхийг,
- Хуулийн 82 дугаар зүйлд ТУЗ-ийн нарийн бичгийн даргын томилгоо, хүлээх үүргийг,
- Хуулийн 84 дүгээр зүйлд компанийн эрх бүхий албан тушаалтны хүлээх үүрэг, хариуцлагыг шинээр хуульчилжээ.

Дээрх хууль эрх зүйн актад Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор баталсан “Компанийн засаглалын кодекс”-т заасан эрсдэлийн удирдлага, дотоод хяналт, мэдээллийн ил тод байдал, оролцогч тал болох ажилчид,

зээлдүүлэгч, харилцагч, ханган нийлүүлэгч, иргэд олон нийтийн эрх ашгийг бүрэн тусгаагүй байна.

1.1.2 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн компанийн засаглалыг үнэлэх тусгайлсан зарчим, аргачлал батлаагүй байна

Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам” нь холбогдох хуулийг дагаж мөрдүүлэх, компанийн засаглалын кодексыг хэрэгжүүлэх, засаглалын түвшнийг сайжруулах, компанийн сайн засаглалын тогтолцоог бий болгоход чиглэжээ.

Журамд хөрөнгийн биржийн I ба II ангилалд бүртгэлтэй, хувьцаа нь биржээр арилжаалагддаг хувьцаат компаниуд засаглалын үнэлгээг 2 жил тутамд хийлгэнэ гэж заасан бол нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүд сайн дурын үндсэн дээр¹, мөн ТУЗ-ийн хараат бус гишүүн эсвэл компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр² засаглалын үнэлгээ хийлгэнэ гэж заажээ. Энэ нь орон нутгийн өмчит компанийн засаглалыг заавал үнэлэх, түвшин тогтоох зохицуулалт биш учраас орон нутгийн өмчит хувьцаат компанид засаглалын үнэлгээ хийгдэхгүй байна.

Дээрх журамд компанийн засаглалын кодекс тусгагдсан дотоод хяналтын тогтолцоо, эрсдэлийн удирдлагыг үнэлэх зэрэг засаглалыг үнэлэх шалгуур үзүүлэлтүүд багтаагүй байна.

1.1.3 Орон нутгийн эрх бүхий байгууллагын үйл ажиллагааны хөтөлбөрт компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилт, үндсэн чиглэлийг тусгаагүй байна

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 69 дүгээр тогтоолоор “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг баталснаар Компанийн тухай хуулийг шинэчлэн найруулж баталжээ. Мөн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд төрийн өмчийн төлөөлөгчийн эрх үүрэг, эрх бүхий байгууллагын хяналт, 21¹ дүгээр зүйлд төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны төлөвлөлт, тайлагналтын талаар тус тус нэмж тусгасан хөтөлбөртэй уялдсан байна.

Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрт “Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн компанийн засаглалын кодекс, бизнес эрхлэх зарчим, ёс зүй, хэв шинжид тулгуурласан, аж ахуйн үйл ажиллагаа удирдан зохион байгуулах нийтлэг арга барил бүхий үндэсний компани, бизнес эрхлэгчдийг бий болгох” зорилгыг хэрэгжүүлэх 4 зорилт дэвшүүлж, 2011-2016 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлэхээр баталжээ.

Хөтөлбөрт тусгасан компанийн засаглалын кодекс, бизнес эрхлэх ёс зүйг хэрэгжүүлэх эрх зүй эдийн засгийн таатай орчин бүрдүүлэх, төрийн байгууллагын

¹ Журмын 3.2-т “Олон нийтээс хөрөнгө татан төвлөрүүлж, нийтийн ашиг сонирхлын төлөө үйл ажиллагаагаа явуулдаг аливаа компаниуд засаглалын үнэлгээг сайн дурын үндсэн дээр хийлгэж болно. Үүнд: 3.2.1. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани”

² Журмын 3.3.3-т “Компани нь дараах тохиолдолд засаглалын үнэлгээг хийлгэнэ. Үүнд: 3.3.3. Компанид засаглалын түвшинд үүссэн хямралаас шалтгаалан хувьцаа эзэмшигчдийн эрх ашиг зөрчигдөж байна гэж үзсэн тохиолдолд ТУЗ-ийн хараат бус гишүүн эсвэл компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн хүсэлтээр”

манлайлал, удирдлага, менежментийг сайжруулах, оролцогч тал, төлөөллийн байгууллагын чадавхыг бэхжүүлэх зэрэг зорилтуудад үндэслэн Засгийн газрын 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулсан байна. Үүнд:

- Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 5.2-т “Эдийн засаг, бизнесийн эрх зүйн орчны тогтвортой байдлыг чухалчилж, шаардлагатай өөрчлөлт хийхдээ эрх ашиг нь хөндөгдөх этгээдээс заавал асууж, саналыг нь авах соёлыг хэвшүүлэх зарчмыг баримтална” гэсэн зорилтын хүрээнд 8 арга хэмжээ,
- Засгийн газрын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.4-т “Шүүгчийн хараат бус, шүүхийн бие даасан байдлыг хангаж, хүний эрх, эдийн засаг, бизнесийн орчныг дэмжсэн хууль тогтоомжийн шинэчлэлийг хийж, шударга ёс, хуульт ёсыг бэхжүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд 5 арга хэмжээ тусгагджээ.

Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн зорилт, үндсэн чиглэлийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт, хэрэгжүүлэх арга хэмжээтэй уялдсан эсэхийг харьцуулахад 2016-2020 онд оролцогч талуудын чадавхыг бэхжүүлэх, төрийн байгууллагын манлайлал зэрэг зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөөгүй бол 2020-2024 онд төлөвлөсөн арга хэмжээг дээрх үндэсний хөтөлбөрийн зорилттой агуулгын хувьд уялдуулсан байна.

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, хадгалалт хамгаалалтыг сайжруулахад чиглэсэн бодлогыг хэрэгжүүлж ажиллана” гэсэн зорилтын хүрээнд 2, 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт зорилт тусгагдаагүй нь орон нутгийн өмчит компанийн засаглалыг хөгжүүлэх бодлого, хөтөлбөрийг төлөвлөөгүй, хэрэгжүүлж ажиллаагүйг харуулж байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2011 оны 187 дугаар тогтоолоор хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Компанийн засаглалын үндэсний зөвлөлийг байгуулсан³ бөгөөд зөвлөл нь хөтөлбөрийн 4.6-д заасны дагуу “Компанийн засаглалын үндэсний тайлан”-г 2013⁴, 2015⁵ онд олон нийтэд нээлттэй мэдээлжээ.

Дээрх хөтөлбөрийн хугацаа дууссан хэдий ч нийтийн ашиг сонирхлын төлөө ажилладаг компаниудын засаглалыг илүү сайжруулах шаардлага байгааг харгалзан 2015 онд “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийн зорилтыг үргэлжлүүлэн хангуулах тухай” 444⁶ дүгээр тогтоолыг баталж, хөтөлбөрийн хэрэгжилтийг олон нийтэд мэдээлээгүй байна.

Орон нутгийн өмчит “Дархан-Ус суваг” ХК үүсгэн байгуулагдсанаас хойш компанийн ТУЗ, гүйцэтгэх удирдлагаас компанийн засаглалын үнэлгээ хийлгэх хүсэлт гаргаагүй бөгөөд Компанийн засаглалын үндэсний зөвлөлөөс үнэлгээ хийж, түвшин тогтоогоогүй байна.

³ Эх сурвалж: <http://www.governance.mn/upload/files/2017/01/24/bb423f0f29cea51245769dab0ea4724d.pdf>

⁴ Эх сурвалж: <http://governance.mn/upload/files/2017/01/26/e6dc2a107cecf5c913af350af6d9bae6.pdf>

⁵ Эх сурвалж: <http://governance.mn/upload/files/2016/01/07/c6eca79876616ea9a1ca86172d0805f7.pdf>

⁶ Эх сурвалж: <http://governance.mn/upload/files/2017/01/24/bb423f0f29cea51245769dab0ea4724d.pdf>

1.2 Орон нутгийн өмчит компанийн бодлого шийдвэр хуульд нийцээгүйгээс засаглалыг хөгжүүлэх зорилт хэрэгжихгүй байна

1.2.1 Орон нутгийн эрх бүхий байгууллагаас компанийн засаглалыг хөгжүүлэх бодлого шийдвэр гаргаагүй байна

Төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийн компанийн засаглалыг хөгжүүлэхэд Компанийн тухай хууль болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиас гадна Засгийн газрын 2011 оны 69 дүгээр тогтоолоор баталсан “Компанийн засаглалыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, Засгийн газрын үйл ажиллагааны үйл ажиллагааны хөтөлбөр, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталжээ.

Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 162 дугаар тогтоолоор баталсан “Компанийн засаглалын кодекс”, 2016 оны 34 дүгээр тогтоолоор баталсан “Компанид засаглалын үнэлгээ хийх, түвшин тогтоох журам” зэрэгт өөрчлөлт оруулаагүй нь компанийн засаглалыг хөгжүүлэх бодлого журам шинэчлэлт хийгдээгүй байна.

Мөн орон нутагт аймгийн Засаг даргын 4 жилийн мөрийн хөтөлбөрт засаглалыг хөгжүүлэх зорилт, арга хэмжээг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулаагүйгээс компанийн засаглалыг хөгжүүлэх бодлого шийдвэр хангалтгүй байна.

“Дархан-Ус суваг” ХК-ийн хувьд ТУЗ нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13⁷-т заасан бүрэн эрхийн хүрээнд жил бүрийн бизнес төлөвлөгөөг баталдаг бөгөөд 2021 оны 005 дугаар тогтоолоор “Компанийг 2021-2025 онд хөгжүүлэх стратеги төлөвлөгөө” баталсан нь сайшаалтай байна. Мөн 2014 онд ТУЗ-ийн үйл ажиллагааны журам, ТУЗ-ийн дэргэдэх хороод болон нарийн бичгийн даргын ажиллах журмыг 2021 онд шинэчлэн баталжээ.

1.2.2 Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуульд заасан эрхээ хэрэгжүүлээгүйгээс ТУЗ-ийн тогтоол шийдвэр хуульд нийцэхгүй байна

Орон нутгийн өмчит “Дархан-Ус суваг” ХК-ийн ТУЗ нь Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4⁸, 76 дугаар зүйлийн 76.1.2⁹-т заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйгээс хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулаагүй, тогтоол шийдвэр гаргаагүй байна.

Түүнчлэн Дархан-Уул аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоолоор компанийн ТУЗ-ийн гишүүдийг томилсон нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7¹⁰, 77 дугаар зүйлийн 77.1¹¹-д заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх, компанийн дүрмийн 7.2-т заасан ТУЗ-ийг гишүүдийг сонгох заалтуудтай тус тус нийцэхгүй байна. Тогтоолоор компанийн ТУЗ-д аймгийн ИТХ-ийн 6 төлөөлөгч болон нарийн бичгийн дарга, аймгийн ЗДТГ-ын дарга зэрэг албан тушаалтнуудыг

⁷ ТУЗ, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны болон компанийн засаглалын дотоод журмыг батлах

⁸ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг ТУЗ /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна.

⁹ Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах

¹⁰ ТУЗ-ийн гишүүнийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох

¹¹ Энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар ТУЗ-ийн гишүүнийг сонгоно.

томилсон нь Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4¹²-т заасан ТУЗ-ийн дэргэдэх хороодын хараат бус гишүүний тоо бүрдэхгүйд хүрчээ.

Мөн компанийн дүрмийг ТУЗ-ийн 2012 оны 72 дугаар тогтоолоор шинэчлэн баталсан нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.1-д “Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах” гэж заасантай нийцэхгүй байна.

Компанийн ТУЗ нь хурлын тусгайлан гаргасан төлөвлөгөөгүй, сүүлийн 3 жилд нийт 22 удаа буюу жилд дунджаар 7 удаа хуралдсан нь ТУЗ-ийн хурлыг Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1-д заасан сард нэг удаа хуралдуулах, компанийн дүрмийн 7.3-т заасан ТУЗ тусгайлан гаргасан төлөвлөгөөний дагуу тогтмол хуралдах гэсэн заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Эдгээр зөрчлүүдийн улмаас тус компанийн ТУЗ-ийн бүрэн эрх хуулийн 59 дүгээр зүйлийн 59.5¹³, 75 дугаар зүйлийн 75.6¹⁴-д заасны дагуу дуусгавар болж, эрхээ хэрэгжүүлэх чадваргүйд тооцогдож байна.

Компанийн ТУЗ жил бүрийн бизнес төлөвлөгөө баталж байгаа боловч төлөвлөгөөний зорилтын хэрэгжилтийг хэлэлцээгүй дүгнээгүй байна. Аудитаар бизнес төлөвлөгөөнд тусгасан зорилтын хэрэгжилтийг шалгахад 2019 онд 100 хувь хэрэгжсэн бол 2020 онд “Цэвэр усны алдагдлыг 14.4 %-д барих”, “Цэвэр усны хүртээмжийг нэмэгдүүлж хэрэглэгчдийн тоог өсгөх”, “Өр төлбөрийг 300 сая төгрөгөөр бууруулах” зэрэг зорилт хэрэгжээгүйгээс 40 хувь, 2021 онд “Цэвэр усны алдагдлыг 14.4 %-д барих”, “Нийт орлогыг өмнөх оноос 9 хувиар өсгөх”, “Өр төлбөрийг 300 сая төгрөгөөр бууруулах” зэрэг зорилт хэрэгжээгүйгээс 40 хувийн гүйцэтгэлтэй байна.

¹² Хувьцаат компани болон төрийн өмчийн компанийн ТУЗ нь ес буюу түүнээс дээш гишүүнтэй байх ба тэдгээрийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

¹³ Энэ хуулийн 59.4-т заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хуралдуулаагүй тохиолдолд ТУЗ /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахаас бусад энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон бүрэн эрх дуусгавар болно

¹⁴ Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлаас энэ хуулийн 75.4-т заасан тооны хараат бус гишүүнийг ТУЗ-д сонгож чадаагүй тохиолдолд тухайн компанийн ТУЗ нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүйд тооцогдоно.


БҮЛЭГ 2. НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН ХҮРЭЭНД ЗАРЦУУЛСАН ХАНДИВ ТУСЛАМЖ АЛДАГДЛЫГ НЭМЭГДҮҮЛСЭН БАЙНА

2.1. Эдийн засгийн зорилтот түвшнийг үндэслэлгүй төлөвлөсөн байна

2.1.1 Компанийн зорилтот түвшний тодотголыг хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэлгүй байна

Компани жил бүрийн эдийн засгийн зорилтот түвшний саналыг боловсруулахдаа өмнөх 5 жилийн гүйцэтгэлд тулгуурлан төлөвлөж, ТУЗ-ийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж байна. Сүүлийн 3 жилийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг графикаар харуулбал:

Дүрслэл №1. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл



Орлогыг төлөвлөгөөг үзэхэд жилд дунджаар нийт орлогын 95-97 хувийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр төлөвлөжээ.

Компанийн төлөвлөсөн орлого 2019 онд 1.6 хувиар буюу 90.6 сая, 2020 онд 66.5 хувь буюу 3,839.0 сая, 2021 онд 13.5 хувь буюу 771.2 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.


Эх сурвалж: 2019-2021 оны санхүүгийн тайлан

Дархан-Уул аймгийн Засаг даргын 2020 оны 4 дүгээр сарын 16-ны өдрийн хуралдаанаар тус компаниар 31 дүгээр хорооллын дэд бүтцийн ажлыг гүйцэтгүүлэхээр шийдвэрлэсэнтэй холбоотойгоор 4,652.5 сая, шугам хоолойн засварын ажлын хөлс 208.9 сая, нийт 4,861.4 сая төгрөгийн үндсэн бус үйл ажиллагааны орлого төвлөрсөн нь нийт орлого давж биелэхэд нөлөөлжээ.

Дүрслэл №2. Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Төлөвлөсөн зардлыг 2019 онд 5.0 хувь буюу 453.8 сая, 2020 онд 37.8 хувь буюу 3,361.3 сая, 2021 онд 0.7 хувь буюу 66.1 сая төгрөгөөр тус тус хэтрүүлэн зарцуулжээ.

Төлөвлөсөн зардлыг хэтрүүлсэн нь дээрх үндсэн бус үйл ажиллагааны орлого, зардлыг төлөвлөгөөнд



Эх сурвалж: 2019-2021 оны санхүүгийн тайлан

зардлыг төлөвлөгөөнд тусгаагүй, тодотголыг хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслэн боловсруулж батлуулаагүйтэй холбоотой байна. (Дэлгэрэнгүйг Хавсралт №1-ээс үзнэ үү)

Байгууллагын бизнес төлөвлөгөөг 2019 онд 4 удаа, 2020 онд 1 удаа, 2021 онд 2 удаагийн тодотгосон нь зорилтот түвшнийг үндэслэлтэй төлөвлөөгүйг нь харуулж байна. Бизнес төлөвлөгөөнд алдагдлыг 2019 онд 3,364.5 сая, 2020 онд 3,115.9 сая, 2021 онд 2,960.6 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд нийт зардлын 43.7 хувийг элэгдлийн зардал эзэлж байна.

2.1.2 Орон нутгийн өмчит компанийн эдийн засгийн зорилтот түвшнийг ТУЗ-өөс өөр эрх бүхий байгууллага хянаж баталдаггүй байна

Орон нутгийн өмчит компанийн эдийн засгийн зорилтот түвшнийг компанийн ТУЗ баталдаг бөгөөд өөр эрх бүхий байгууллагаар хянаж батлуулах хуулийн зохицуулалт байхгүй болно.

2.1.3 Тус компанийн эдийн засгийн зорилтот түвшнийг ТУЗ-ийн хурлаар хэлэлцэн баталж байна

ТУЗ-ийн аудитын хороо компанийн зорилтот түвшний төсөлд 2019 онд дүгнэлт гаргаагүй бол 2020 онд 10 нэр төрлийн зардлыг 772.3 сая төгрөгөөр бууруулах, 2021 онд төслийг дэмжсэн дүгнэлт гаргажээ. ТУЗ 2020 онд 200.0 сая төгрөгөөр зардлыг бууруулж, 2019, 2021 онуудад бизнес төлөвлөгөөний саналыг хэвээр баталжээ.

Компанийн 60 хувийг аймгийн ИТХ, 40 хувийг аймгийн Засаг даргын Тамгын газар эзэмшиж байна. Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4-д “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг ТУЗ /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн шийдвэрээр санхүүгийн жил дууссанаас хойш дөрвөн сарын дотор зарлан хуралдуулна” гэж заасны дагуу үйл ажиллагааны тайлангаа аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлж, гарсан саналын хэрэгжилт, тайлан мэдээ хангалтгүй байна.


2.2. Төлөвлөсөн орлогоо сүүлийн 3 жил давуулан биелүүлжээ

2.2.1. Борлуулалтын орлогыг бүрэн төвлөрүүлж чадаагүй байна

Усны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-т “Ус ашиглагч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь ус, рашааны нөөц ашигласны төлбөр төлнө” гэж заасны дагуу “Дархан-Ус суваг” ХК нь 14,280 айл өрх, 1,580 аж ахуйн нэгж, байгууллагыг цэвэр усаар хангах, бохир усыг татан зайлуулах ашиглалтын гэрээ байгуулан ажиллаж байна.

Дүрслэл №3. Борлуулалтын төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая төгрөгөөр)



Эх сурвалж: 2019-2021 оны санхүүгийн тайлан

Графикаас харахад төлөвлөсөн орлого биелсэн ч, борлуулалтын авлага 2019 онд 648.7 сая, 2020 онд 836.2 сая, 2021 онд 1,300.8 сая төгрөгт хүрсэн байна. Үүнд: 2019 онд айл өрхийн 464.6 сая, ААНБ-ын 184.1 сая, нийт 648.7 сая, 2020 онд айл өрхийн 342.6 сая, ААНБ-ын 168.1 сая, нийт 510.7 сая, 2021 онд айл өрхийн 131.9 сая, ААНБ-ын 110.6 сая, нийт 242.5 сая төгрөгийн борлуулалтын авлага байна.

Авлагын хэмжээ сүүлийн жилүүдэд буурч байгаа нь бодитой ажил зохион байгуулж ажилласны үр дүн юм. Тухайлбал: Жил бүр авлага барагдуулах аяныг зохион байгуулж их хэмжээний өр төлбөртэй айл өрх, аж ахуйн нэгжүүдийг шүүхэд өгч эвлэрлийн гэрээ байгуулан авлага барагдуулж ажиллажээ.

Харин Монгол улсын Засгийн газрын 2020 оны 211 дүгээр тогтоолоор Коронавируст халдвар цар тахлын үед айл өрх, ААНБ-ын цэвэр бохир усны төлбөрийг төрөөс хариуцах шийдвэрийн дагуу 2020 онд 325.6 сая төгрөг, 2021 онд 951.8 сая төгрөгийн борлуулалтын авлага бий болсон байна.

Айл өрх, ААНБ-ын борлуулалтын авлага өмнөх оноос буурсан ч нийт авлагын дүнд төрөөс хариуцах усны төлбөр 2020 онд 40 хувь, 2021 онд 73 хувийг эзэлж байгаагаас байгууллагын хэвийн үйл ажиллагаанд сэргээр нөлөөлөх нөхцөл үүсжээ.

Санхүүгийн хяналт, аудитын албаны шалгалтаар дутуу тооцоолсон 23.1 сая төгрөгийн зөрчлийг арилгуулахаар төлбөрийн акт тогтоосон нь орлогыг бүрэн тооцож төвлөрүүлээгүйг харуулж байна.

2.2.2. Татвар, төлбөр хураамжийн өр өмнөх оноос буурсан байна

“Дархан-Ус суваг” ХК нь Монгол Улсын татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т заасны дагуу дараах төрлийн татварыг төсөвт төвлөрүүлж байна. Үүнд:

- Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар,
- Нэмэгдсэн өртгийн албан татвар,
- Хувь хүний орлогын албан татвар,
- Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар,
- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар,
- Усны нөөц ашигласны татвар,
- Газрын төлбөр
- Бусад татвар

Хүснэгт №1. Татварын өрийн судалгаа

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2019 он	2020 он	2021 он
Усны нөөц ашигласны татвар	74.9	25.1	49.8
Газрын төлбөр	10.4	5.4	
ХХОАТ-ын өглөг	80.7	66.9	50.5
НӨАТ-ын өглөг	694.5	427.4	443.7
Үл хөдлөх хөрөнгийн татвар	18.9	15.7	7.1
НДШ-ийн өглөг	126.1	352.7	246.0
Бусад татвар	14.5	7.8	
Нийт дүн	1,020.0	901.0	797.1

Эх сурвалж: 2019-2021 оны санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтэд нийт татварын өр 2020 онд 119.0 сая төгрөг буюу 12 хувиар, 2021 онд 103.9 сая төгрөг буюу 11.5 хувиар тус тус буурчээ.

Тайлант онд ноогдох татваруудыг нягтлан бодох бүртгэлд тусгаж ирсэн ч өмнөх шалгалтуудаар НӨАТ-ыг дутуу тооцож илэрхийлснийг бүртгэл, тайланд залруулсан байна. Тухайлбал:

- Санхүүгийн тайлангийн аудитаар төрөөс хариуцсан усны төлбөрийн орлого 151.4 сая төгрөгийг өглөгөөр бүртгэснийг залруулснаар 13.8 сая төгрөгийн НӨАТ-ыг тооцон бүртгэлд тусгуулсан.
- Санхүүгийн хяналт, аудитын албаны шалгалтаар 10.9 сая төгрөгийн НӨАТ-ыг нягтлан бодох бүртгэлд дутуу илэрхийлснийг, ногдуулаагүй орхигдуулсан байгалийн нөөц ашигласны төлбөр 1.3 сая төгрөгийг төсөвт тус тус төвлөрүүлжээ.

2.3. Усны борлуулалтын үнэ бүтээгдэхүүний өртгөөс бага байна

2.3.1. Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн үр ашгийн тооцоо, шинжилгээ бодитой байна

Компанийн 2021-2025 оны “Стратеги төлөвлөгөө” боловсруулахад сүүлийн 5 жилийн санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн шинжилгээ үнэлгээнд үндэслэсэн байна. Үүнд:

- Санхүүгийн үзүүлэлтүүдийн шинжилгээ,
- Санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлж буй хүчин зүйлийн судалгаа,
- Санхүүгийн эрсдэлийн шинжилгээний аргуудыг ашиглан үнэлгээ хийжээ.

Санхүүгийн үзүүлэлтийн шинжилгээгээр 111.8 сая төгрөгийн сэлбэг материалын үлдэгдэл агуулахад байгаа нь 2020 онд 31 дүгээр хорооллын бүтээн байгуулалтын ажлыг хийж гүйцэтгэснээс шалтгаалжээ.

Нийт хөрөнгийн хэмжээ 2018 онд 32,000.0 сая төгрөгт хүрсэн нь хөрөнгийн дахин үнэлгээ хийснээс шалтгаалсан бөгөөд борлуулалтын өртөг 5 жилийн дунджаар 185.5 хувиар өссөн нь орлогын өсөлтөөс 54.9 хувиар өндөр байгаа нь дараах санхүүгийн үзүүлэлтүүд нөлөөлжээ. Үүнд:

- Хөрөнгийн дахин үнэлгээнээс үүдэлтэй 2,000.0 сая төгрөгийн элэгдлийн зардал шинээр үүссэн
- Байгууллагын 55 жилийн ойг угтсан бүтээн байгуулалт болон нийгмийн шинжтэй олон ажилд их хэмжээний зардал гаргасан,

- Төв цэвэрлэх байгууламжийн шинэчлэлтэй холбоотойгоор тодорхой үлдэх өртөгтэй барилга байгууламжийг акталсантай холбоотой.

Санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлж буй хүчин зүйлийн судалгаагаар бие даалтын коэффициент нь 2020 оны хувьд 0.92 буюу сайн, хараат байдлын коэффициентийн хэмжээ 1.08 байгаа нь зээлдүүлэгчдэд эрсдэл бага, зээлийн оролцооны коэффициент 0.078 буюу сайн, ашгаар зээлийн хүү төлөх чадвар ашиггүй ажилласан учраас муу үзүүлэлттэй байна.

Санхүүгийн эрсдэлийн шинжилгээгээр Альтманы индексээр тооцоолсноор 2.675 гэж гарсан нь санхүүгийн хангалттай тогтвортой байдалд байгааг харуулсан үр дүн гарчээ.

2.3.2. Санхүүгийн үйл ажиллагааны үр ашгийн тооцоо шинжилгээ хийсэн боловч дүгнээгүй байна

“Дархан-Ус суваг” ХК-ийн ТУЗ-ийн тогтоолоор бизнес төлөвлөгөөнд зохицуулалт хийх нөхцөл үүссэний улмаас 2019 онд 4 удаа тодотгон нийт зардлыг 3,029.6 сая, 2020 онд 1 удаа тодотгон нийт зардлыг 147.3 сая, 2021 онд 2 удаа тодотгон нийт зардлыг 123.3 сая төгрөгөөр тус тус нэмж баталжээ.

Хүснэгт №2. Батлагдсан орлого, зардлын төлөвлөгөө, тодотгол

Үзүүлэлт	2019 он		2020 он		2021 он	
	Анх батлагдсан	Тодотгол	Анх батлагдсан	Тодотгол	Анх батлагдсан	Тодотгол
Орлого	5,589.7	5,589.7	5,771.3	5,771.3	5,455.3	5,715.6
Зардал	5,589.7	8,954.3	8,739.9	8,887.2	8,552.9	8,676.2
Ашиг(алдагдал)	-	(3,364.6)	(2,968.6)	(3,115.9)	(3,097.6)	(2,960.6)

(сая төгрөгөөр)

Эх сурвалж: 2019-2021 оны санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс үзэхэд 2019, 2020 онуудад орлогын төсөв, тодотголоор нэмэгдээгүй, 2021 онд өмнөх оноос буурч төлөвлөсөн нь усны хэрэглээний өсөлтийг тооцож тусгаагүйтэй холбоотой байна. Тухайлбал:

- Дархан-Уул аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэдээллээс 2019 онд 497, 2020 онд 231, 2021 онд 318 өрх, айл шинээр орон сууцанд орсон,
- Судалгаагаар гэр хорооллын хэрэглэгчдийн хэрэглээ жил ирэх тусам өссөн,
- Шинээр шугам хоолойн засварын захиалгат ажил гүйцэтгэсэн,
- ХСУХАТАҮЗЗ-ийн 2020 оны 93 дугаар тогтоолоор төсөвт байгууллагуудын цэвэр, бохир усны үнийн тарифт өөрчлөлт орсон зэргийг тооцож орлогын төсвийг нэмэгдүүлэхээр байжээ.

Нийт зардлын төсөв, тодотголоор нэмэгдсэн нь Засгийн газраас төрийн албан хаагчдын цалин нэмэгдүүлсэнтэй холбоотой байгууллагын албан хаагчдын цалин, үнэ төлбөргүй шилжиж ирсэн болон худалдан авсан, дахин үнэлгээнээс нэмэгдсэн үндсэн хөрөнгөтэй холбоотой элэгдлийн зардал, баяр ёслол, ойн арга хэмжээ, тусламж дэмжлэг, спортын арга хэмжээ, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санхүүжүүлэх зэргээс шалтгаалжээ. (Хавсралт №2-оос үзнэ үү)

Зардлын төсвийг боловсруулахдаа Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-ийн “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж

өгөхийг хориглоно”, Засгийн газраас гаргасан “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолууд, ТУЗ-ийн гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний 3.3-т “Захирал компанийн тухайн жилийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлж хүргэх түвшинг бизнес төлөвлөгөөний үзүүлэлтийн дагуу биелүүлэн компанийн ашиг орлогыг нэмэгдүүлэх үндсэн үүрэг хүлээнэ” гэснийг мөрдлөг болгоогүй байна.

Үйл ажиллагаанд нийлүүлсэн бүтээгдэхүүний 1 тонн цэвэр усны өртөг 2,593 төгрөг, бохир усны өртөг 2,461 төгрөг, гэр хорооллын айл, өрхийн усны өртөг 2,077 төгрөг байгаа бол борлуулж буй үнэ орон сууцанд амьдардаг айл өрх 1 тонн цэвэр усыг 1,014, бохир усыг 1,105, гэр хорооллын айл өрх 1 тонн усыг 1,364, үйлдвэр ААНБ-д 1 тонн цэвэр усыг 1,885, бохир усыг 2,030 төгрөгөөр тус тус борлуулж байна. Үүнээс шалтгаалж байгууллагын нийт ахиуц ашиг -0.406, цэвэр ахиуц ашиг -0.556, хөрөнгө оруулалтын өгөөж -0,085 гэсэн сөрөг үзүүлэлттэй гарчээ.

Хүснэгт №3. Ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээний орлого, зардлын тооцоо
(сая төгрөгөөр)

Үйлчилгээний төрөл	Зардал	Орлого	Ашиг/алдагдал
Цэвэр ус	5,349.3	1,997.0	(2,912.7)
Усны суурь хураамж		439.6	
Бохир ус	3,251.5	2,311.1	(940.4)
Дүн	8,600.8	4,747.7	(3,853.1)

Эх сурвалж: 2019-2021 оны санхүүгийн тайлан

Орлого, зардлын үзүүлэлтээс үзэхэд алдагдалтай байгаа нь цэвэр бохир усны үнэ тарифыг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

“Дархан-Ус суваг” ХК хэрэглээний усны худалдан борлуулах үнийг нэмэх хүсэлтийг ХСУХАТАУ33-д хүргүүлснээр 2021 оноос тарифт өөрчлөлт оруулж, усны үнийг 30 хувиар нэмэх шийдвэр гаргажээ.

2.3.3. Шинээр байгуулах хорооллын дэд бүтцийн ажлыг гэрээний хугацаанд гүйцэтгэжээ

Дархан-Уул аймгийн Засаг даргын зөвлөлийн 2020 оны 4 дүгээр сарын 16 өдрийн хуралдаан, аймгийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу Дархан сумын 9, 10 дугаар багт баригдах амины орон сууцны 31 дүгээр хорооллын 425 айлын дэд бүтцийн ажлыг аймгийн Захирагчийн ажлын алба төлөвлөн, гүйцэтгэгчээр “Дархан-Ус суваг” ХК-ийг сонгож гэрээ байгуулах шийдвэр гарсан байна.

Дээрх ажлын гүйцэтгэлээр нийт 4,574.5 сая төгрөгийн санхүүжилт авч, 3,650.3 сая төгрөгийн зарцуулан гэрээний хугацаанд гүйцэтгэн комисст хүлээлгэн өгчээ.

2.4. Хандив тусламжийн зардал алдагдлыг нэмэгдүүлсэн байна

2.4.1. Батлагдсан төсвийн зардлыг хэтрүүлэн зарцуулсан байна

“Дархан-Ус суваг” ХК-ийн бизнес төлөвлөгөөг жил бүр ТУЗ-ийн хурлаар батлуулан, тодотголоор орлого, зардлын төсөв, худалдан авалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан байна. Үүнд:

Хүснэгт №4. Зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая төгрөгөөр)

	2019 он		2020 он		2021 он	
Зардлын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл

Үйл ажиллагааны зардал	6,229.4	6,501.4	6,748.3	6,677.5	6,718.7	6,548.8
Үйл ажиллагааны бус зардал	1,287.2	1,064.0	602.9	4,061.8	403.1	676.1
Борлуулалт ба удирдлагын зардал	1,437.7	1,658.4	1,535.9	1,453.5	1,554.4	1,520.3
Дүн	8,954.3	9,223.8	8,887.2	12,192.8	8,676.2	8,745.2

Эх сурвалж: 2019-2021 оны санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс үзэхэд 2019 онд үйл ажиллагааны зардал 272.0 сая төгрөгөөр хэтэрсэн нь ажилтан, албан хаагчдын цалин, үндсэн хөрөнгө нэмэгдсэнээр цалингийн болон элэгдлийн зардал өссөн, 2020 онд үйл ажиллагааны бус зардал 3,458.9 сая төгрөгөөр хэтэрсэн нь Дархан хотын 31 дүгээр хорооллын инженерийн шугам, сүлжээний угсралтын ажилд 3,650.3 сая төгрөг зарцуулсан, 2021 онд үйл ажиллагааны бус зардал 273.0 сая төгрөгөөр хэтэрсэн нь тэтгэмжийн зардал 35.6 сая, төлөвлөгдөөгүй 237.4 сая төгрөг зарцуулснаас шалтгаалжээ.

Удирдлагын зардал 2019 онд 220.7 сая төгрөгөөр хэтэрсэн нь томилолтын зардал 39.4 сая, түүхий эд материалын зардал 78.2 сая, усны төлбөр 10.0 сая, бусдаар гүйцэтгүүлэх ажил 10.6 сая, төлөвлөгөөнд тусгагдаагүй зардал 28.6 сая, цалин болон үндсэн хөрөнгө нэмэгдсэнээс цалин, элэгдлийн зардал өссөнөөс голлон шалтгаалжээ.

Харин ТУЗ-ийн гишүүдэд сүүлийн жилүүдэд алдагдалтай ажиллаж байгаа тул үр дүнгийн урамшуулал олгоогүй байна.

2.4.2. Нийгмийн хариуцлагын хүрээний зардлыг 82.4 сая төгрөгөөр хэтрүүлсэн байна

“Дархан-Ус суваг” ХК нь 8 хэлтэс, алба нэгжид хөдөлмөрийн гэрээгээр 206 үндсэн ажилтан, түрээсийн гэрээгээр 19 хүн, хамгаалах салаанд 20 хүн, нийт 245 ажилтантайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.

Хүснэгт №5. Цалингийн зардлын төлөвлөгөө, гүйцэтгэл

Зардал	2019 он		2020 он		2021 он	
	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл
Цалин	2,073.9	2,087.5	2,381.0	2,243.6	2,501.0	2,463.6

Эх сурвалж: 2019-2021 оны санхүүгийн тайлан

Байгууллагын бизнес төлөвлөгөөгөөр батлагдсан орон тоо, цалингийн санд багтаан цалинг олгож ирсэн ч Санхүүгийн хяналт, аудитын албаны шалгалтаар ээлжийн амралтын олговор, ажилласан хугацааны цалингийн давхардлыг арилгуулахаар шийдвэрлэн 1.6 сая, хамтын гэрээ зөрчин олгосон мөнгөн тэтгэмжийн зөрүү 7.2 сая төгрөгийн төлбөрийн актуудыг тогтоосон байна.

Унааны зардалд 0.3 сая төгрөг илүү олгосныг аудитын явцад төлж барагдуулсан.

Компанийн ТУЗ-ийн хурлаар жил бүр нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулах зардлыг батлуулж ирсэн байна.

Хүснэгт №6. Нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулах зардлын төсөв, гүйцэтгэл

Үзүүлэлт	2019 он		2020 он		2021 он	
	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл	Төсөв	Гүйцэтгэл

	Төсөв	Гүйц	Зөрүү	Төсөв	Гүйц	Зөрүү	Төсөв	Гүйц	Зөрүү
Нийгмийн хариуцлагын хүрээнд	412.2	408.4	(3.8)	70.0	101.5	31.5	84.7	73.4	(11.3)

Эх сурвалж: 2019-2021 оны санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс үзэхэд 2019, 2021 онд батлагдсан төсөв хэтрээгүй ч арга хэмжээ тус бүрд зарцуулах зардал хэтэрсэн байна. Тухайлбал: 2019 онд аймгийн наадмын арга хэмжээг 0.39 сая, гэр бүлийг дэмжих жилийн хүрээнд 8.77 сая, цэцэрлэгт хүрээлэн тохижуулахад 0.79 сая, аж ахуй нэгж, хувь хүнд туслах, хамтран ажиллахад 31.3 сая, аймгийн шилдэг хүүхдүүдийг ОХУ-д аялуулах, амраахад 1.7 сая төгрөгөөр, 2020 онд найдваргүй авлагын нөөц 30.8 сая, 25 дугаар цэцэрлэгийн шугамын ажил 4.0 сая төгрөгөөр 2021 онд НАМЭХ -ний гишүүдийг ОХУ-ын Улан-Үдэ хотод аялахад 4.6 сая, нийт 82.4 сая төгрөгөөр тус тус хэтэрч байгууллагын алдагдлыг нэмэгдүүлсэн байна.

Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-д “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” гэж заасны зөрчиж, нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулах зардлаас 2019 онд 231.5 сая, 2020 онд 63.8 сая, 2021 онд 7.7 сая, нийт 303.0 сая төгрөгийг хандив тусламж, ойн арга хэмжээ, жүжгийн билет, аялал, наадам, уралдаан тэмцээний дэмжлэг, сургалт зэрэгт зарцуулжээ.

2.4.3. Төлөвлөгөөнд тусгагдаагүй худалдан авалт хийсэн байна

Худалдан авах төлөвлөгөөг боловсруулан ТУЗ-өөр батлуулж ирсэн ч харьцуулалтын аргаар хийх худалдан авалтыг tender.gov.mn сайтад байршуулалгүй худалдан авалт хийсэн, батлагдсан төсвийг хэтрүүлсэн зэрэг алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:

Батлагдсан төсөв хэтрүүлсэн

2019 онд

- Конторын засвар диспетчерийн өрөө 13.7 сая,
- Зулзагын гол амралтын газар 16.0 сая,
- Нийт шугам хоолой, хаалт арматурын шинэчлэлт 31.5 сая,
- Тавилга эд хогшил 4.6 сая,
- Авто машины сэлбэг 26.3 сая, нийт 92.1 сая төгрөгөөр

2020 онд

- Принтер 1.6 сая,
- Тавилга эд хогшил 2.8 сая, нийт 4.4 сая төгрөгөөр хэтэрсэн нь гүйцэтгэх захиралтай байгуулсан гэрээний 3.5-д “Захирал нь бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа ТБОНӨХБАҮХАТ хуулийн зүйл заалтыг дагаж мөрдөж ажиллана” гэж заасантай нийцэхгүй байна.

Tender.gov.mn сайтад байршуулаагүй шууд худалдан авалт хийсэн

2019 онд

- Грундфосс SP160-4AA насос 30.0 сая,
- Автограшийн хэсэгчилсэн дээврийн засвар 56.2 сая,

- Конторын засвар диспетчерийн өрөө 51.3 сая,
- Зулзага амралтын газрын засвар, тоног төхөөрөмж 195.1 сая,
- Нийт шугам хоолой, хаалт арматурын шинэчлэлт 51.5 сая,
- Авто машины сэлбэг худалдан авах 49.6 сая, нийт 433.7 сая төгрөгийн худалдан авалт хийсэн нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1-т *“үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх”* гэж заасантай нийцэхгүй байна.

Мөн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй дараах худалдан авалт хийжээ. Үүнд:

2019 онд

- Усан оргилуурын иж бүрэн байгууламж 32.2 сая,
- 34 ш ус түгээх байрны гадна пасад 42.0 сая,
- Насжилт өндөр солих шаардлагатай 17 цэгийн цэвэр усны шугамын зураг төсөв 9.1 сая, нийт 83.3 сая төгрөг

2020 онд

- Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр /2020-2023/ 1.5 сая,
- “Амин эрдэнэ дуу” 9.2 сая,
- “Амин цэнхэр урсгал” баримтат кино 9.0 сая
- Грундфосс SP160-4AA насос хөдөлгүүр 32.7 сая,
- Цэцэрлэгийн барилга барих эскиз зураг 6.0 сая, нийт 58.4 сая төгрөг байна.

Хөрөнгө оруулалтаар худалдан авсан 2.5 сая төгрөгийн төгөлдөр хуур хуучин, ашиглалтгүй, ажилчдын 9 давхар орон сууцны барилгын зургийг 116.0 сая, ажилчдын хүүхдийн цэцэрлэгийн барилга барих ажлын зургийг 6.0 сая төгрөгөөр хийлгэсэн ч барилгыг хэзээ хэдийд, хаанахын хөрөнгө оруулалтаар хийх нь тодорхойгүй зэрэг үр ашиггүй худалдан авалт хийсэн байна.

Иймд гүйцэтгэх захирал ТУЗ-тай байгуулсан гэрээний 3 дугаар зүйлийн 3.3-т заасан ашиг, орлогыг нэмэгдүүлэх, компанийн хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд үр ашигтай зүйлд зарцуулах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. ХӨНДЛӨНГИЙН ХЯНАЛТ ҮР НӨЛӨӨТЭЙ БАЙГАА БОЛОВЧ ДОТООД ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

3.1. Хөндлөнгийн хяналт үр нөлөөтэй байна

3.1.1 Орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тавих төрийн байгууллагуудын хяналт үр нөлөөтэй байна

Аймгийн “Мэргэжлийн хяналтын газар” болон “Ус цаг уур орчны шинжилгээний төв”-өөс төв цэвэрлэх байгууламжийн хаягдал усны химийн шинжилгээ, цэвэр ус түгээх барилга байгууламж, тоног төхөөрөмжид төлөвлөгөөт болон улирал тутмын хяналтыг тогтмол хэрэгжүүлжээ. Ундны хэрэгцээнд түгээж буй уснаас дээж авч аймгийн МХГ-ын дэргэдэх лабораторийн хими, нян судлалын шинжилгээнд хамруулж зөвлөмж, албан шаардлага хүргүүлснийг хэрэгжүүлжээ.

“Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл”-өөс жил бүрийн зорилтын хэрэгжилт болон үйл ажиллагааны тайланг 2019 онд 66 хувь буюу “Дунд”, 2020 онд 71 хувь буюу “Дунд”, 2021 онд 71 хувь буюу “Дунд” гэж үнэлсэн байна.

Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газраас “Төрийн байгууллагуудын дотоод аудитын тогтолцоо, чиг үүргийн хэрэгжилт”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар байгууллагын дотоод аудиторыг хууль, дүрэмд нийцүүлэн, албан тушаалын тодорхойлолтод заасан дотоод аудитын чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх албан шаардлага өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тус компанийн цэвэр усны хангамж, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулж, цэвэрлэх үйл ажиллагаанд чанарын менежментийн тогтолцоонд Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3¹⁵-т заасны дагуу Стандарт хэмжил зүйн газрын даргын тушаалаар аудит хийжээ. Аудитын тайлан, дүгнэлтээр 2017-2019 онд зөрчил илрээгүй бөгөөд 2020 онд өгсөн 12 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн нь хяналт шалгалт үр нөлөөтэй болсныг харуулж байна.

3.1.2 Төрийн байгууллагуудаас санхүүгийн үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн хяналт үр нөлөөтэй байна

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу жилийн эцсийн санхүүгийн тайлангаа Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт хуулийн хугацаанд нь хүргүүлсэн байна. Аудитад хамрагдаж буй хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар 3,420.0 сая төгрөгийн алдаа зөрчлийг илрүүлж, аудитын явцад 151.4 сая төгрөгийн алдааг залруулж, алдаа, зөрчлийг арилгуулах 136.7 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлж, 2.4 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, цаашид үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах 3,129.5 сая төгрөгийн 3 зөвлөмж өгснийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Дархан-Уул аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2019-2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалтыг хэрэгжүүлэн 49.9 сая төгрөгийн 7 зөрчилд төлбөрийн акт тогтоосон бөгөөд хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.

¹⁵ энэ хуулийн 13.2-т зааснаас бусад бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, нийлүүлэгч, хэрэглэгчийн хүсэлтээр тохирлын үнэлгээнд хамруулж болно

Дээрх хяналт шалгалтын байгууллагын дүнгээр 3,129.5 сая төгрөгийн зөрчлийг арилгуулж, төсөвт 49.9 сая төгрөгийг буцаан төвлөрүүлэхээр тогтоосон нь санхүүгийн үйл ажиллагаанд тавих бусад байгууллагын хяналт үр нөлөөтэй байгааг харуулж байна.

3.2. Санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна

3.2.1 Компанийн ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа хангалтгүй байна

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1-д “ТУЗ нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно” гэж заасны дагуу аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хороодыг байгуулжээ.

ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны бүрэлдэхүүнд хараат бус гишүүнийг томилоогүй нь Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2-т “Хувьцаат компанийн ТУЗ нь аудитын, цалин, урамшууллын, нэр дэвшүүлэх хороодтой байх бөгөөд эдгээр хороодын гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүдээс бүрдэнэ”, 81.4-т “Энэ хуулийн 81.2-т заасан аудитын хорооны дарга нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байх бөгөөд уг хороо нь дараах чиглэлээр дүгнэлт гаргаж, ТУЗ-д танилцуулна” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Аудитаар ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагааны хэрэгжилтийг шалгахад аудитын хороо актлах үндсэн хөрөнгө, бизнес төлөвлөгөөний саналд нийт 6 удаа дүгнэлт гаргасан бол цалин урамшууллын хорооноос чиг үүргийн дагуу хяналт тавиагүй, нэр дэвшүүлэх хорооноос эрх бүхий албан тушаалтныг нэр дэвшүүлэх санал ТУЗ-д оруулаагүй байна.

Энэ нь дээрх хороод ТУЗ-ийн 2021 оны 8 дугаар тогтоолоор баталсан “ТУЗ-ийн аудитын хорооны ажиллах журам”, “Цалин урамшууллын хорооны ажиллах журам”, “Нэр дэвшүүлэх хорооны ажиллах журам”-д заасан чиг үүргээ хэрэгжүүлж ажиллаагүйг харуулж байна.

3.2.2 Компанийн дотоод хяналт нь санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хийгээгүй байна

Компанийн удирдлага Засгийн газрын 2013 оны 311 дүгээр тогтоолын дагуу “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ыг баталснаар дотоод хяналтын мэргэжилтэн хууль тогтоомжийн хэрэгжилт, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаа, үйлдвэрлэлийн төлөвлөгөөний гүйцэтгэл, хувь хүний хөгжил зэрэг үндсэн 4 чиглэлээр хяналт шалгалт хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мэргэжилтэн сүүлийн 3 жилийн байдлаар нийт 91 ажил төлөвлөснөөс санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой шалгалт хийгдээгүйгээс 75.8 хувийг хэрэгжүүлж, байгууллагын 7 нэгжид 399 зөвлөмж өгч, хэрэгжилт 86.3 хувьтай гарчээ.

Төлөвлөгөөний дагуу санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалтыг хийгээгүй нь “Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.3.5-д “Компанийн өмчийн бүртгэл тооцоо, ашиглалт, хадгалалт, хамгаалалт, санхүү бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих” заалтыг хэрэгжүүлээгүй байна. Түүнчлэн хөндлөнгийн хяналт шалгалт болон санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчил дутагдал буурахгүй байгаа нь санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийгээгүйтэй холбоотой байна.

Компанийн дотоод хяналтын мэргэжилтэн ЗУХХ-т харьяалагдаж байгаа нь Засгийн газрын 311 дүгээр тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 3 дугаар зүйлийн 3.2-т “Дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагад шууд захирагдах бөгөөд зохион байгуулалтын хувьд бусад бүтэц, нэгжээс хараат бус байна” гэж заасантай нийцэхгүй байна.

3.3. Компанийн мэдээллийн ил тод байдал хангалтгүй байна

3.3.1 Дээд шатны байгууллагуудаас гаргасан өмч хөрөнгөтэй холбоотой шийдвэрүүдийг хэрэгжүүлж ажиллажээ

Хуульд заасны дагуу санхүүгийн тайлангийн аудитыг хийлгэж, жил бүрийн үйл ажиллагааны тайланг ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар танилцуулж байна.

Байгууллагын жилийн эцсийн үндсэн хөрөнгийн тооллогоор ашиглагдахгүй болсон хөрөнгөд өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт гарган аймгийн Орон нутгийн өмчийн газарт хүсэлт хүргүүлснээр аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, Засаг даргын захирамжийг үндэслэн үндсэн хөрөнгийг акталж байна.

3.3.2 Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг олон нийтэд мэдээлээгүй байна

Компанийн гүйцэтгэх удирдлага санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг ТУЗ-д, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралд танилцуулж байна.

Мөн “Дуут үзэг” НҮТББ сайт, “Цахим дархан” ТББ, “Дархан мэдээлэл Төв” ХХК-ийн телевизүүдтэй гэрээ байгуулан засвар үйлчилгээтэй холбоотой мэдээллийг байршуулж байгаа ч байгууллагын darkhan-ussuvag.mn цахим сайтад хүний нөөц, төсөв санхүү, үйл ажиллагааны мэдээ тайлангаа байршуулахгүй байна.

ТУЗ болон хувьцаа эзэмшигч, олон нийтэд вэбсайтаар болон бусад хэлбэрээр мэдээлэл хангалтгүй хүргэж байгаагаас үйл ажиллагааны ил тод байдал хангалтгүй байгаа нь харагдаж байна.

Холбогдох байгууллагаас ирсэн санал:



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
“ДАРХАН-УС СУВАГ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ**

213800 Дархан, Дархан-Уул аймаг,

Утас/Факс: (01372) 33702

№ 02
төрийн аудитын газарт № 038 -ны

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Тус компани дээр хийгдсэн “Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг” гүйцэтгэлийн аудитын тайлан, алдаа зөрчлийн бүртгэлтэй танилцлаа, зөрчлийг арилгаж, цаашидын үйл ажиллагаандаа тусгаж хэрэгжүүлж ажиллах болно.

ДАРГА

Г. ЭРДЭНЭСҮХ

У. Батсүрэн-д
Аудитын тайлан
Холбогдох байгууллагаас
Хургуучь



**ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
“ДАРХАН-УС СУВАГ”
ХУВЬЦААТ КОМПАНИ**

45043 Дархан-Уул аймаг, Дархан сум 8-р баг
Утас/Факс: 7037-3702

2022.07.01 № 01/399
танай 2022.06.29 -ны № 538 -т

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ**

Тус газраас ирүүлсэн “Дархан-Ус суваг” ХК-ийн
“үйл ажиллагааны үр ашиг” гүйцэтгэлийн аудитын
тайлангийн төсөлтэй танилцлаа.

Өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж, биелэлтийг
хуулийн хугацаанд нь хүргүүлэн ажиллах болно.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Г.ЭРДЭНЭБАТ



У.Дабсүрэн-9
Аудитын тайланг
халдсандаа байгууллагад
хүргүүлнэ.



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН
ХУРАЛ

45059 Дархан-Уул аймаг, Дархан, 14 дүгээр баг
Утас/Факс: 7037-7880
Web: darkhan-uul.khural.mn

Додл. 07. 01 № 72
танай Додл. 07. 01 -ны № 339 -Т

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР ТАНАА

“Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн
оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр
ашиг” гүйцэтгэлийн аудитыг “Дархан-Ус суваг”
ХК-ийн 2019-2021 оны үйл ажиллагаанд хийсэн
аудитын тайлантай танилцлаа.

Цаашид зөвлөмжийг хэрэгжүүлж,
хэрэгжилтийг хангаж ажиллах болно.

ДАРГА

С.НАСАНБАТ



У.Батсүрэн-г
Аудитын тайланг
Голбогдох байгууллагад
Хургуулье.

452205122

D:/toot1.docx



ДАРХАН-УУЛ АЙМАГ
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

45059 Дархан, Дархан-Уул аймаг,
Утас/Факс: 7037-7121,
И-мэйл: info@darkhan.gov.mn
Вэбсайт: www.darkhan.gov.mn

2022.07.01 № 2-10/941
танай _____-ны № _____-т

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ш.МӨНХБАЯР
ТАНАА

“Дархан-Ус суваг” ХК-ийн 2019-2021 оны үйл
ажиллагаанд хийсэн аудитын тайлангийн төсөлтэй
танилцлаа. Дархан-Уул аймгийн Төрийн аудитын
газраас ирүүлсэн зөвлөмжийн дагуу “Дархан-Ус суваг”
ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгож
томилох болон компанийн дүрмийг батлахтай
холбоотой зөрчлийг арилган ажиллах болно.



ДАРГА

О.ХҮРЭЛЧУЛУУН

У.Батсүрэн-г
Аудитын байр-аас
халбаргах байгууллагад
сургууль.

4522102045

2022 Тoot-2

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна.

- Орон нутгийн өмчит хувьцаат компанийн засаглалыг хөгжүүлэх бодлого шийдвэр хангалтгүй байна.
- Компанийн ТУЗ хувьцаа эзэмшигчдийн хурлын хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлжээ.
- Компанийн ТУЗ-д хуульд заасан тооны хараат бус гишүүдийг сонгоогүйгээс бүрэн эрхээ хэрэгжүүлэх чадваргүйд тооцогдож байна.
- Бизнес төлөвлөгөөг боловсруулахдаа холбогдох судалгаа, мэдээллийг бүрэн ашиглаагүй, хүлээгдэж буй гүйцэтгэлд үндэслээгүй байна.
- ТУЗ-ийн дэргэдэх хороодын үйл ажиллагаа явуулах журмын хэрэгжилт хангалтгүй, гүйцэтгэх удирдлагын дэргэдэх дотоод хяналтын мэргэжилтэн санхүүгийн үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийгээгүй байна.
- Орлого бүрэн төвлөрөөгүйгээс 2021 онд борлуулалтын авлага өнгөрсөн оноос 43 хувиар өссөн байна.
- Санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн үр ашгийн тооцоо шинжилгээ бодитой байна.
- Нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулсан хандив тусламжийн зардал алдагдлыг нэмэгдүүлсэн байна.
- Компанийн санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээ тайланг олон нийтэд мэдээлэхгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.
Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга С.Насанбат, ЗДТГ-ын дарга О.Хүрэлчулуун нарт:

1. Компанийн ТУЗ-ийн гишүүнийг сонгохдоо Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1-д заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэх,
2. Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.4-т заасан хараат бус гишүүнийг сонгохдоо 79 дүгээр зүйлийн 79.1-д заасан шалгуурыг баримтлах,
3. Компанийн дүрмийг хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэх

“Дархан-Ус суваг” ХК-ийн ТУЗ-ийн дарга Г.Эрдэнэсүхэд:

1. Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 76 дугаар зүйлийн 76.1.2-т заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах бүрэн эрхээ хэрэгжүүлэх,
2. ТУЗ-ийн хурлыг Компанийн тухай хуулийн 80 дугаар зүйлийн 80.1-д заасны дагуу сард нэг удаа хуралдуулах
3. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг Компанийн тухай хуулийн 81 дугаар зүйлийн 81.2-т заасан хараат бус гишүүдээс бүрдүүлж, хууль журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллах

“Дархан-Ус суваг” ХК-ийн гүйцэтгэх захирал Г.Эрдэнэбатад:

1. Бизнес төлөвлөгөөний зорилтот түвшнийг холбогдох хууль дүрэм журам, судалгаа мэдээлэл, хүлээгдэж буй гүйцэтгэлд тулгуурлан үндэслэлтэй боловсруулах,
2. Нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулж байгаа хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэхгүй байх,
3. Үр ашиггүй хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэхгүй байх, батлагдсан төсвийг баримталж ажиллах,
4. Харьцуулалтын аргаар зохион байгуулсан тендерийг худалдан авах ажиллагааны цахим сайтад байршуулж, үр дүнг тайлагнаж ажиллах
5. Засгийн газрын 2013 оны 311 дүгээр тогтоолын дагуу компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтыг хэрэгжүүлэх
6. Байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг олон нийтэд ил тод нээлттэй мэдээлэх

Зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 30-ны дотор багтаан Дархан-Уул аймгийн Төрийн аудитын газарт ирүүлэх.

ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
2022.07.01

ХАВСРАЛТУУД:

Хавсралт №1

“Дархан-Ус суваг” ХК-ийн эдийн засгийн зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

(сая төгрөгөөр)

Үзүүлэлт	2019 оны эдийн засгийн зорилтот түвшин					2020 оны эдийн засгийн зорилтот түвшин					2021 оны эдийн засгийн зорилтот түвшин				
	2018 оны гүйц	2019 оны төл	2019 оны гүйц	өмнөх оноос	тайлант оны гүйц-с	2019 оны гүйц	2020 оны төл	2020 оны гүйц	өмнөх оноос	тайлант оны гүйц-с	2020 оны гүйц	2021 оны төл	2021 оны гүйц	өмнөх оноос	тайлант оны гүйц-с
Үндсэн үйл ажиллагааны орлого	5,107.1	5,395.3	5,434.7	288.2	(39.4)	5,434.7	5,668.3	4,747.7	233.7	920.7	4,747.7	5,611.6	6,084.8	863.9	(473.2)
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	110.1	194.5	245.8	84.4	(51.3)	245.8	102.9	4,862.6	(142.9)	(4,759.7)	4,862.6	103.9	402.0	(4,758.7)	(298.1)
НИЙТ ОРЛОГО	5,217.2	5,589.8	5,680.5	372.6	(90.7)	5,680.5	5,771.3	9,610.3	90.8	(3,839.0)	9,610.3	5,715.6	6,486.8	(3,894.7)	(771.2)
Үндсэн үйл ажиллагааны зардал	5,382.2	7,667.1	8,159.8	2,284.9	(492.8)	8,159.8	8,284.2	8,131.0	124.4	153.2	8,131.0	8,276.1	8,069.1	145.1	206.9
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	594.4	1,287.3	1,248.3	692.9	39.0	1,248.3	603.0	4,117.4	(645.3)	(3,514.5)	4,117.4	403.1	676.2	(3,714.3)	(273.0)
НИЙТ ЗАРДАЛ	5,976.5	8,954.3	9,408.1	2,977.8	(453.8)	9,408.1	8,887.2	12,248.4	(520.9)	(3,361.3)	12,248.4	8,679.2	8,745.3	(3,569.2)	(66.1)
АШИГ, АЛДАГДАЛ	(759.3)	(3,364.5)	(3,727.6)	(2,605.2)	363.1	(3,727.6)	(3,115.9)	(2,638.1)	611.7	(477.7)	(2,638.1)	(2,963.6)	(2,258.5)	(325.5)	(705.2)

Хавсралт №2

"Дархан-Ус суваг" ХК-ийн 2021 оны төлөвлөгөө, тодотгол

(сая төгрөгөөр)

д/д	ҮЗҮҮЛЭЛТ	2021 оны батлагдсан төлөвлөгөө	Тодотгол-1	Тодотгол-2	Зөрүү
1	Элэгдлийн зардал	3,586.8	3,614.5	3,614.5	27.7
2	Дэлхийн усны өдөр	4.0	4.0	4.0	-
3	Эх үрсийн баяр (Гэр бүл хамт олон өдөрлөг)	5.0	5.0	5.0	-
4	МНААХуйн баяр, 90 жилийн ой	4.5	4.5	14.5	10.0
5	Байгууллагын шинэ жил	17.0	17.0	17.0	-
6	Ажилчдын хүүхдүүдэд бэлэг (шинэ жил)	3.0	3.0	3.0	-
7	Намрын спортын тэмцээн	3.0	3.0	3.0	-
8	Хамтын гэрээний дагуу	30.0	30.0	30.0	-
9	Өндөр насны тэтгэвэрт гарах ажилчдад тэтгэмж	105.6	105.6	105.6	-
10	Ахмадын сан (цагаан сар, ахмадын баяр, бусад арга хэмжээ)	24.0	24.0	24.0	-
11	Нийгмийн хариуцлагын хүрээнд аж ахуй нэгж, хувь хүнд туслах, хамтран ажиллахад	20.0	30.0	30.0	10.0
12	Дархан-Уул аймгийн 60 жилийн ойн арга хэмжээ	15.0	15.0	5.0	(10.0)
13	Ажил олгогч эздийн холбоо	1.0	1.0	1.0	-
14	МНААХолбооны гишүүнчлэлийн төлбөр	1.0	1.0	1.0	-
15	ДУС-н Эмэгтэйчүүд, залуучуудын зөвлөл	8.0	8.0	8.0	-
16	Ус сувгийн байгууллагуудтай хамтран ажиллах	8.0	4.0	4.0	(4.0)
	Дүн	3,835.9	3,869.6	3,869.6	33.7

Ажлын баримтын нэр:	Алдаа, зөрчилтэй асуудлын бүртгэл
Аудитын код:	ДАА-2022/22-7-ШТА-ГА
Аудитын нэр:	"Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой хуулийн этгээдийн үйл ажиллагааны үр ашиг"-д хийсэн гүйцэтгэлийн аудит

(сая.төгрөгөөр)

Алдаа, зөрчлийн товч утга	Хэрэгжилт тооцох хугацаа		Мөнгөн дүн	Хариуцах аудитор	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
	Хүлээлгэн өгсөн	Барагдуулах				Албан тушаал	Овог нэр
1	5	6	7		8	9	10
Төлбөрийн акт тогтоох							
Унааны мөнгийг илүү олгосон.	2022.06.29	2022.07.30	0.3	Ч.Гантулга	Төлбөрийн акт тогтоох	"Дархан-Ус суваг" ХК-ийн нягтлан бодогч	Д.Уранчимэг
Төлбөрийн актын дүн			0.3				
Зөвлөмж							
Компанийн ТУЗ-ийн гишүүдийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлээгүй.	2022.07.01	2022.11.30	-	У.Батсүрэн	Зөвлөмж өгөх	Дархан-Уул аймгийн ИТХ-ын дарга, ЗДТГ-ын дарга	С.Насанбат О.Хүрэлчулуун
Компанийн ТУЗ-д хараат бус гишүүдийн хуульд заасан шалгуурын дагуу сонгож томилоогүй	2022.07.01	2022.11.30	-	У.Батсүрэн	Зөвлөмж өгөх		
Хувьцаа эзэмшигчдийн хурал Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүйгээс компанийн дүрмийг ТУЗ-ийн тогтоолоор баталсан.	2022.07.01	2022.11.30	-	У.Батсүрэн	Зөвлөмж өгөх		
Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4, 76 дугаар зүйлийн 76.1.2-т заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй байна.	2022.07.01	2022.11.30	-	У.Батсүрэн	Зөвлөмж өгөх	"Дархан-Ус суваг" ХК-ийн ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга	Г.Эрдэнэсүх, А.Баттөр

ТУЗ-ийн хурлыг хуулийн 80 дугаар зүйлийн 80.1-д заасны дагуу сард нэг удаа хуралдаагүй байна.	2022.07.01	2022.11.30	-	У.Батсүрэн	Зөвлөмж өгөх	“Дархан-Ус суваг” ХК-ийн ТУЗ-ийн дарга, нарийн бичгийн дарга	Г.Эрдэнэсүх, А.Баттөр
ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг Компанийн тухай хуулийн 81 дугаар зүйлийн 81.2-т заасан хараат бус гишүүдээс бүрдүүлж, хууль журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлээгүй байна.	2022.07.01	2022.11.30	-	Н.Отгонцэцэг	Зөвлөмж өгөх		
Бизнес төлөвлөгөөний зорилтот түвшнийг холбогдох хууль дүрэм журам, судалгаа мэдээлэл, хүлээгдэж буй гүйцэтгэлд тулгуурлан үндэслэлтэй боловсруулаагүй.	2022.07.01	2022.11.30	-	Ч.Гантулга, Н.Отгонцэцэг	Зөвлөмж өгөх	“Дархан-Ус суваг” ХК-ийн гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, эдийн засагч	Г.Эрдэнэбат, Д.Уранчимэг, Л.Оюундарь
Нийгмийн хариуцлагын хүрээнд зарцуулж байгаа хөрөнгийг батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулсан.	2022.07.01	2022.11.30	-	Ч.Гантулга	Зөвлөмж өгөх		
Үр ашиггүй хөрөнгө оруулалтыг санхүүжүүлж, батлагдсан төсвийг баримталж ажиллаагүй.	2022.07.01	2022.11.30	-	Ч.Гантулга	Зөвлөмж өгөх		
Харьцуулалтын аргаар зохион байгуулсан тендерийг худалдан авах ажиллагааны цахим сайтад байршуулж, үр дүнг тайлагнаагүй.	2022.07.01	2022.11.30	-	Ч.Гантулга	Зөвлөмж өгөх		
Засгийн газрын 2013 оны 311 дүгээр тогтоолын дагуу компанийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналт хэрэгжүүлээгүй.	2022.07.01	2022.11.30	-	Н.Отгонцэцэг	Зөвлөмж өгөх		
Байгууллагын санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг олон нийтэд ил тод нээлттэй мэдээлээгүй.	2022.07.01	2022.11.30	-	Н.Отгонцэцэг	Зөвлөмж өгөх		
Зөвлөмжийн дүн			-				
Алдаа зөрчлийн нийт дүн			0.3				